

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Зорилго

Энэхүү Ёс зүйн дүрэм (“Дүрэм”)–ээр Премиум Нэксус ХК болон түүний охин, хараат компаниуд (“Компани”)–ын ажилтан, гэрээт ажилтан, бизнесийн түнш, бэлтгэн нийлүүлэгч болон бусад оролцогч талууд дагаж мөрдөх ёстой бизнесийн ёс зүйн зарчмуудыг тодорхойлно. Энэхүү зарчмууд нь эрүүл байгууллагын соёлд тулгуурлан үйлчлүүлэгчдэд үнэ цэнэ бий болгох, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах, ажилтан болон оролцогч талуудын эрхийг хүндэтгэж, сэтгэл хангалуун байдлыг дэмжихэд чиглэнэ.

1.2. Хамрах хүрээ

Компанийн нийт ажилтан, ажиллагсад гэрээт ажилтан, бэлтгэн нийлүүлэгчид, бизнесийн түншүүд гэх мэт Компанийн үйл ажиллагаанд оролцогч (“Хамтрагч”)–ид энэхүү Дүрмийг дагаж мөрдөнө.

1.3. Хяналт, нэмэлт өөрчлөлт

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)–ийн Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо (“БОНЗ Хороо”) тухай бүр, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэхүү Дүрэм болон түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг ТУЗ-д танилцуулах ба аливаа өөрчлөлтийг ТУЗ баталснаар хүчин төгөлдөр мөрдөнө.

1.4. Дүрмийн нөхцөл

Энэхүү Дүрэм нь Компанийн Дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байх энэхүү дүрэмд заасан зарчимд тулгуурлана. Хэрэв энэхүү Дүрэм болон Компанийн дүрмийн хооронд зөрчил үүссэн тохиолдолд Компанийн Дүрэм давуу хүчинтэй байна. Мөн уг Дүрмийн аливаа заалт нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцээгүй тохиолдолд сүүлд батлагдсан хуулийн зохицуулалт давуу хүчинтэй байна. Энэхүү Дүрмийн заалтыг тайлбарлах, хэрэглэхтэй холбоотой тодорхойгүй байдал, санал зөрөлдөөн үүссэн тохиолдолд түүнийг ТУЗ шийдвэрлэнэ. Дүрэмд тусгагдаагүй аливаа асуудлыг Компанийн тухай хууль, Компанийн Дүрэм болон холбогдох бусад эрх зүйн актад зааснаар шийдвэрлэнэ.

1.5. Нэр томьёо

Энэхүү Дүрэмд хэрэглэсэн зарим нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 1.5.1. “**Ашиг сонирхол**” гэж эрх бүхий албан тушаалтан болон ажилтнууд нь албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн зүгээс нөлөөлж болзошгүй эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;
- 1.5.2. “**Давуу байдал**” гэж Компанийн аливаа ажилтан, албан тушаалтан нь албан тушаалын эрх мэдлээ ашиглан, өөртөө эсхүл бусад Компани, хувь хүн, хуулийн этгээдэд эдийн болон эдийн бус ашигтай нөхцөл бүрдүүлсэн байдлыг;
- 1.5.3. “**Эрх бүхий албан тушаалтан**” гэж ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх захирлын орлогч, Санхүү хариуцсан захирал болон ТУЗ-өөс эрх бүхий албан тушаалтнаар томилсон аливаа этгээдийг;
- 1.5.4. “**Удирдах албан тушаалтан**” гэж Компанийн газар, алба, хэлтэс, эсвэл нэгжийн захирал, дарга, менежерийг;
- 1.5.5. “**Ажилтан**” гэж Компанитай хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллуулах болон бусад төрлийн гэрээ хэлцлийн дагуу ажил үүрэг гүйцэтгэж буй аливаа этгээдийг;
- 1.5.6. “**Хамаарал бүхий этгээд**” гэж тухайн ажилтан, албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн эцэг, эх, дүү, төрөл, садан, найз нөхөд болон бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;

- 1.5.7. **“Нэгдмэл сонирхолтой этгээд”** гэж тухайн ажилтан, албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;
- 1.5.8. **“Зөрчил”** гэж энэхүү Дүрэм болон холбогдох эрх зүйн актын заалтыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;
- 1.5.9. **“Ёс зүйн хороо”** гэж Компанийн ажилтан ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар зөвлөмж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ТУЗ-өөс тогтоосон орон тооны бус байгууллагыг;
- 1.5.10. **“Сонирхлын зөрчил”** гэж Компанийн ажилтны хувийн сонирхол нь эрхэлж буй албан тушаал, гүйцэтгэж буй ажил үүрэг болон Компанийн ашиг сонирхолтой зөрчилдөж, албан үүргээ зүй зохистой, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;
- 1.5.11. **“Шүгэл үлээх үйл ажиллагааны журам”** гэж ТУЗ-ийн тогтоолоор батлагдаж, тухай бүр өөрчлөлт орсон хүчин төгөлдөр журмыг;
- 1.5.12. **“Мөнгө угаах”** гэж аливаа орлого, эд хөрөнгийг хууль бусаар олсон гэдгийг урьдчилан мэдсээр байж, түүний эх үүсвэр, гарал үүслийг нуун далдалж уг орлого, эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор түүнийг гүйлгээнд оруулахыг;
- 1.5.13. **“Терроризмыг санхүүжүүлэх”** гэж террорист байгууллага болон террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж, аливаа хэлбэрээр эд хөрөнгө хуримтлуулах, шилжүүлэх, зарцуулахыг;
- 1.5.14. **“Хээл хахууль, авлига”** гэж хувийн ашиг хонжоо олоход эрх мэдэл, албан тушаал, байр суурь нөхцөл байдлыг урвуулан ашиглах, бусдад давуу тал олгосны төлөө өөрт болон бусдад эдийн засгийн болон эдийн засгийн бус ашиг хонжоо бий болгох, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдээс хууль бус давуу байдлыг олж авахад зориулсан мөнгө, хөрөнгө, мэдээлэл, бэлэг дурсгал зэрэг биет болон биет бус бүх зүйлсийг хамруулан ойлгоно.

2. Ёс зүйн зарчим

- Бид үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд цаг үеийн хэрэгцээнд нийцсэн, сайн, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж, үйлчлүүлэгчийн хэрэгцээ, хүлээлтийг хангахад чиглэсэн шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- Бид хууль тогтоомж, ёс зүйн дүрэмд нийцэж ажиллахыг нэн тэргүүний зорилт хэмээн үзэж, ажил болон хувийн асуудлыг ялгаж, ажлаа чанартай гүйцэтгэнэ.
- Бид харилцан итгэлцлийн үндсэн дээр бүх хамтран ажилладаг хувь хүн, байгууллагуудыг ялгаварлалгүй тэгш нөхцөлөөр харилцах, чухал бизнесийн хамтрагч хэмээн үзэж, ижил тэгш боломж олгож, хамтдаа хөгжихийг эрмэлзэнэ.
- Бид хамтран ажилладаг байгууллага, төрийн албан тушаалтан зэрэг бүх оролцогч талуудтай харилцахдаа шударга бус хүсэлтээс татгалзаж, мөнгө, үнэт зүйл, цайллага, санхүүгийн гүйлгээ, баталгаа зэрэг ёс суртахуунгүй үйлдлүүд гаргахгүй, шударга бусаар ашиг олохгүй.
- Бид Компанийн өмч хөрөнгө, холбогдох мэдээлэл, албан тушаалын байдлаа хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй бөгөөд бусдын итгэлийг эвдэх, завших, ашиглах зэрэг хууль бус үйлдэл хийхгүй.
- Бид ил тод, шударга удирдлагын арга барилаар Компаниа тогтвортой хөгжүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн, урт хугацааны ашгаар хангахыг хичээж ажиллана.
- Бид харилцан итгэлцэл, хүндэтгэлд суурилсан, хүний эрхийг дээдэлсэн эрүүл байгууллагын соёлыг бий болгож, нийт ажилтнуудын амьдралын чанарыг сайжруулахыг эрмэлзэнэ.

НЭГ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ӨМНӨ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3. Үйлчлүүлэгч

- 3.1. Үйлчлүүлэгчид өндөр сэтгэл ханамж үлдээх үйлчилгээ үзүүлэхийн тулд үйлчлүүлэгчийн зүгээс ирж буй санал, гомдлыг нээлттэйгээр, олон төрлийн сувгуудаар хүлээн авч, үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулж ажиллана.
- 3.2. Үйлчилгээг үзүүлэхдээ үйлчлүүлэгчийг хүндэтгэх нэн тэргүүний зарчмыг баримталж ажиллах бөгөөд харилцаа, үг хэллэг, гаргаж буй үйлдэл бүрд энэхүү зарчмыг удирдлага болгон ажиллана.
- 3.3. Үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг хадгалж, хамгаалах, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг дагаж мөрдөнө.

ХОЁР. ХАМТРАГЧДЫН ӨМНӨ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

4. Тэгш боломж

- 4.1. Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагч, ханган нийлүүлэгч, хамтрагч талуудын эрх ашгийг хүндэтгэж, тэдгээрт эрх тэгш, хүндэтгэлтэй хандаж, итгэлцэл, хүндлэл бүхий хамтын ажиллагааг эрхэмлэн ажиллана.
- 4.2. Ханган нийлүүлэгч, хамтрагч байгууллагыг сонгохдоо тэдгээрийн нийлүүлж буй бараа материал, ажил үйлчилгээний чанар, найдвартай байдал, хүргэх хугацаа, үнэ, бизнесийн тогтвортой байдал, технологийн чадавхыг сайтар нягтлан үзэх болно. Шударга бусаар ялгаварлан гадуурхах явдлыг арилгах, хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийг устгах, байгаль орчныг хамгаалах зэрэг нийгмийн хариуцлагын дадал хэвшилд бид зохих ёсоор анхаарна.
- 4.3. Компани болон Компанийн нийт ажилчид хамтран ажиллах үйл ажиллагааны хүрээнд ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлаас татгалзаж, худалдан авалтын ажиллагаа, гүйлгээнд ханган нийлүүлэгч, хамтрагчдаас аливаа хувийн ашиг тусыг хүлээж авахгүй.
- 4.4. Тухайн чиглэлээр мэргэшсэн байгууллагыг тендерийн сонгон шалгаруулалтад оролцох эрх тэгш боломжоор хангах ба өрсөлдөөнд саад учруулах аливаа үйлдэл хийхгүй.
- 4.5. Хамтрагчийн сонгон шалгаруулалтыг шударга явуулна.

5. Ёс зүйгүй үйлдэл

- 5.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнууд нь өөрийн албан тушаалаа урвуулан ашиглах, хамтрагч байгууллагуудаас аливаа шударга бус, хууль бус үйлдэл хийхийг шаардахгүй.
- 5.2. Компани нь хамтрагч байгууллагуудад шударга бусаар мөнгөн болон мөнгөн бус дарамт учруулахгүй. Дараах ёс зүйгүй үйлдэл, болон эс үйлдэхүйг гаргахыг хориглоно. Үүнд:
 - 5.2.1. Хамтрагч байгууллагад Компанийн ажилчдын аливаа тэмдэглэлт баяр болон гачигдлын талаар шууд болон шууд бус замаар мэдэгдэх;
 - 5.2.2. Хамтрагч байгууллагатай холбоотой ажлыг үндэслэлгүйгээр хойшлуулах, удаашруулах үйлдэл, эс үйлдэхүй гаргах;
 - 5.2.3. Хамтрагч байгууллагаас баяр ёслол, тэмдэглэлт өдөр, албан томилолт, амралт, ажил хэргийн оройн зоог гэх мэт шалтгаанаар мөнгө, эд зүйл, үйлчилгээ болон эдгээртэй адилтгах аливаа урамшуулал, хөнгөлөлт, давуу байдлыг өөртөө болон хамаарал бүхий этгээддээ олж авах.
- 5.3. Хэрэв хамтрагч байгууллага өөртөө болон бусдад давуу байдал олж авах зорилгоор Компанийн эрх бүхий албан тушаалтнууд болон ажилтнуудад энэхүү ёс зүйн дүрмээр хориглосон аливаа бэлэг сэлт, бэлэн мөнгө, эд хөрөнгө, хөнгөлөлт, эрхийн бичиг, давуу байдал гэх мэт үүгээр хязгаарлагдахгүй үнэ бүхий зүйл зүйлийг санал болгосон тохиолдолд тэр даруй татгалзаж,

буцааж өгнө.

- 5.4. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд болон удирдах албан тушаалтнууд хамтын ажиллагааны явцад хүлээн авсан Хамтрагч байгууллагын бизнесийн нууцыг тэдний зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахгүй.
- 5.5. Хэрэв хамтрагч байгууллага нь энэхүү журмын 5.3-т заасан үйлдэл гаргасан тохиолдолд Компанийн удирдлагууд нь тухайн компанитай үүсгэсэн бизнесийн харилцаа, гэрээ, хэлцлийг түдгэлзүүлэх, цуцлах хүртэлх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 5.6. Энэхүү Дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой нөхцөлүүдийг хамтрагчидтай байгуулах гэрээ, хэлцэлд тусгаж ажиллана.

6. Хамтын хөгжлийг эрэлхийлэх

- 6.1. Хамтрагч байгууллагуудыг харилцан итгэлцэл дээр суурилсан бизнесийг дэмжих түнш гэж үзнэ.
- 6.2. Хамтрагч байгууллага нь өрсөлдөх чадвартай болж хөгжихөд нь хууль ёсны дэмжлэг үзүүлэн хамтын хөгжлийг эрэлхийлнэ.
- 6.3. Цэвэр, ил тод худалдааны орчныг бүрдүүлж, шударга бизнесийн дэг журмыг хадгалахын тулд харилцан хүчин чармайлт гаргаж ажиллана.

ГУРАВ. УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНУУД БОЛОН АЖИЛТНУУДЫН ЁС ЗҮЙ

7. ТУЗ-ийн дарга, гишүүн болон удирдах албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээ

- 7.1. Компанийн соёлыг хөгжүүлэх соёл, тэгш байдал, оролцоог хангах;
- 7.2. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад хувийн сонирхлоор хандахгүй, албан тушаалын давуу байдлаа урвуулан ашиглаж бусдад заавар, чиглэл өгөхгүй байх;
- 7.3. Бусдад хүндлэлтэй хандах;
- 7.4. Дотоод мэдээллийг хууль бусаар болон хувийн ашиг сонирхолд ашиглахгүй, задруулахгүй байх;
- 7.5. Аливаа асуудалд үндэслэлтэй, шударга хандах;
- 7.6. Энэхүү Дүрмийг зөрчих үйлдэл, эс үйлдлээс татгалзах, шаардлагатай тохиолдолд бүрэн эрхээсээ татгалзах.

8. Ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээ

- 8.1. Ажилтан өөртөө эерэг зөв сэтгэлгээг бий болгож, өөрийгөө тасралтгүй хөгжүүлж, үнэнч шударгаар ажлаа гүйцэтгэн, Компанийн эрхэм зорилгыг биелүүлэх;
- 8.2. Компани, баг хамт олныхоо нэр хүндийг хадгалах, хамгаалахыг үргэлж хичээнэ.
- 8.3. Энэхүү Дүрмийг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйн талаар мэдээлэлтэй болсон тохиолдолд Ёс зүйн хороонд нэн даруй мэдэгдэнэ.

9. Ажил үүргээ шударгаар гүйцэтгэх

- 9.1. Ажил үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэж, Компанийн дүрэм, журамд заагаагүй тодорхой бус ажлыг гүйцэтгэхдээ ил тод, үндэслэлтэй гүйцэтгэнэ.
- 9.2. Өөрийн үүрэг хариуцлагатай холбоотой үнэнч шударга байдлыг алдагдуулж болзошгүй ямар ч төрлийн үнэ бүхий зүйлийг оролцогч талаас авахгүй.
- 9.3. Удирдах албан тушаалтан нь өөрийн удирдаж буй ажилтанд Монгол Улсын хууль тогтоомж болон Компанийн дүрэм, журамд нийцээгүй ажлын зааварчилгаа, ажлын байрны тодорхойлолтын үүргийн бус даалгавар өгөхгүй ба ийм төрлийн зааварчилгаа, даалгаврыг удирдах албан тушаалтнаас авсан ажилтан тухайн ажлыг гүйцэтгэхээс татгалзана.

9.4. Оролцогч талд зохисгүй хүсэлт гаргах эсхүл тэдгээрээс үнэ бүхий зүйлс авах, шаардах, авахыг завдахыг хориглоно.

9.5. Ажилтны үйлдэл нь Авлигын эсрэг хууль, Компанийн дүрэм, журмыг зөрчсөн буюу зөрчих магадлалтай нь тогтоогдвол холбогдох хууль, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу арга хэмжээ авна.

10. Хүний эрхийг хүндэтгэх

10.1. Ажлын байранд ёс зүйтэй байх ба хамтран ажиллагсдын харилцаанд сөргөөр нөлөөлөх зан харилцаа, үг хэллэг, үйлдэл гаргахгүй.

10.2. Компанид хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгох болон бусад хууль бус шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй хийхийг хориглох бөгөөд Компанийн баг хамт олны дунд зөрчилдөөн үүсгэх зорилгоор эвлэлдэн нэгдэхгүй.

10.3. Ажлын байранд садар самууныг сурталчлах, эротик хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, үүнтэй адилтгах бусад зүйлийг үзэх, тараах зэрэг үйлдлийг хориглоно.

11. Мэдээлэл хамгаалах

11.1. Компанийн үйл ажиллагааны болон бизнесийн нууц, хувь хүний нууцыг чанд хамгаална. Компанийн нууцыг хамгаалахтай холбоотой хууль, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

12. Ашиг сонирхлын зөрчил

12.1. Компанийн нийт ажилтнууд ашиг сонирхлын болзошгүй зөрчлөөс зайлсхийж, ангид байхын зэрэгцээ өөртөө давуу байдал бий болгох зорилгоор Компанийн үйл ажиллагаа, шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх, нөлөөлөхөөр оролдохгүй.

12.2. Компанийн нийт ажилтнууд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй байдлыг Ёс зүйн хороонд мэдэгдэнэ.

12.3. Хувийн ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх боломжгүй тохиолдолд хуулийн хүрээнд Компани болон үйлчлүүлэгчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, уг зөрчлийг Ёс зүйн хороонд мэдэгдэнэ.

13. Мөнгө угаах ба дотоод мэдээлэл ашиглах

13.1. Компанийн эрх бүхий болон удирдах албан тушаалтан, ажилтнууд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг мөрдөн ажиллана.

13.2. Компанийн эрх бүхий болон удирдах албан тушаалтан, ажилтнууд нь Компанийн дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахыг хориглох бөгөөд уг мэдээллийг шууд болон шууд бусаар бусдад дамжуулах, задруулахгүй байх үүрэгтэй.

14. Авлига, хээл хахууль

14.1. Ажилтнаар ёс зүйгүй үйлдэл хийлгэх, эсвэл ажилтны ажлыг зохих ёсоор хийлгэхгүй байхын тулд бэлэг, төлбөр, давуу тал олгохгүй бөгөөд бусдад авлига, хээл хахууль санал болгохгүй, өгөхийг хориглоно.

14.2. Ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа бусдаас бэлэг, төлбөр нэхэхгүй бөгөөд аливаа этгээд энэ төрлийн санал тавьсан тохиолдолд татгалзана.

14.3. Ажилтан ажлаа хийхдээ бусдаас санхүүгийн, өөр бусад давуу тал шаардахгүй, урамшууллын

нөлөө ятгалгад орж ёс зүйгүй үйлдэл гаргахгүй, Компанийн өмнө хүлээсэн үүргээ зөрчихгүй байх үүрэгтэй.

- 14.4. Ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа бусдад зүй бус шагнал, урамшуулал буюу авлига өгөхгүй, Компанийн нэр хүндэд халдахгүй байх үүрэгтэй.

ДӨРӨВ. УЛС БА НИЙГМИЙН ӨМНӨ КОМПАНИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

15. Эрүүл бизнесийн үйл ажиллагаа

- 15.1. Нийгмийн үнэт зүйлсийг хүндэтгэж, Компанийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л хууль тогтоомжийг дагаж мөрдөж, аливаа хууль бус зүйл хийхгүй, зөв шударга үйлдлийг эрхэмлэж, эрүүл, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй бизнесийн үйл ажиллагааг явуулна.
- 15.2. Бизнесийн орчинд нөлөөлөх төр, засгийн бодлого, хууль эрх зүйн асуудалд бид бизнесийн зүй ёсны ашиг сонирхлын үүднээс санал бодлоо илэрхийлэх, холбогдох мэдээлэл өгөх байдлаар оролцоно.
- 15.3. Компани аливаа хууль бус, ёс зүйгүй үйлдлийг дотоод хяналтаар дамжуулан мэдээлэх, мэдэгдэх системийг бий болгоно.
- 15.4. Компанид ашигтай хөрөнгө оруулалт, удирдлага болон ажилтны ажлын бүтээмжийг дээшлүүлэх замаар хувьцаа эзэмшигчдийг урт хугацааны ашигт ажиллагаагаар хангана.
- 15.5. Зөв, шударга удирдах үйл ажиллагааг явуулснаар тогтвортой ашиг олж, компанийн зах зээлийн үнэлгээг тогтмол нэмэгдүүлнэ.
- 15.6. Дотоод мэдээллийн бүрэн бүртгэж, Компанийн дотоод хэрэгцээнд ил тод мэдээллийн санг бий болгох бодлого баримтална.
- 15.7. Компани нь хамтрагч, бэлтгэн нийлүүлэгчтэй хүндэтгэлтэй, ялгаварлан гадуурхахгүй харьцаж аливаа гомдол, хүсэлт саналыг шуурхай шийдвэрлэж, хамтран ажиллана.

16. Улс болон нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах

- 16.1. Компани ажлын байр тасралтгүй бий болгох болон хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах замаар Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ оруулна.
- 16.2. Компани татвараа үнэнчээр тайлагнаж, хуулиар тогтоосон хугацаанд төлнө.
- 16.3. Ажил олгогчийн зүгээс хувь хүний сонгох эрх, улс төрийн үзэл бодлыг хүндэтгэх бөгөөд Компани доторх аливаа улс төрийн үйл ажиллагааг хориглоно.
- 16.4. Компанийн хөрөнгө, хүний нөөц, байгууламжийг улс төрийн зорилгоор ашиглахгүй бөгөөд улс төрийн аливаа нам, байгууллагыг хандив, бусад эд зүйлсээр хангахгүй.
- 16.5. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх эрхтэй хүн бүрийг хөдөлмөр эрхлэх боломжоор эрх тэгш хангана.
- 16.6. Төрийн байгууллага хуулийн этгээдийн хоорондын харилцаанд байгалийн гамшигт үзэгдэл, давагдашгүй нөхцөл байдал үүссэн нөхцөлд хандив, тусламж үзүүлэхийг хориглохгүй.

17. Байгаль орчныг хамгаалах

- 17.1. Компани үйл ажиллагаа явуулахдаа цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлэхийн тулд бүхий л боломжит ажлыг хэрэгжүүлнэ.
- 17.2. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 17.3. Нөөцийг дахин боловсруулах зэргээр нөөцийг үр ашигтай ашиглахад манлайлна.
- 17.4. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд тохижилт, цэвэрлэгээ, байгаль орчныг сайжруулах олон нийтийн үйлсэд нэгдэж болно.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

18. Зөрчлийг мэдээлэх

- 18.1. Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү Дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн байж болзошгүй зөрчил болон гарсан зөрчлийн талаарх мэдээллийг Компанийн Шүгэл үлээх үйл ажиллагааны журамд заасны дагуу Ёс зүйн хороонд нэн даруй хүргүүлнэ.
- 18.2. Ёс зүйн зөрчил нь нотлох баримтаар тогтоогдсон тохиолдолд ёс зүйн зөрчлийг мэдээлсэн ажилтныг Шүгэл үлээх журмын дагуу урамшуулна.

19. Зөрчлийг шийдвэрлэх

- 19.1. ТУЗ-ийн тогтоолоор Компанийн Ёс зүйн хороог байгуулах бөгөөд Ёс зүйн хороонд шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг үзүүлж, бие даасан хараат бус байдлыг хангаж ажиллана.
- 19.2. Ёс зүйн хороо нь ёс зүйн болзошгүй зөрчлийн талаар мэдээлэл авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэж дүгнэлт гаргаж, Гүйцэтгэх захиралд танилцуулна.
- 19.3. Ёс зүйн хорооны гаргасан дүгнэлтийг үндэслэн гаргасан зөрчил, хохирлын хэмжээг харгалзан Гүйцэтгэх захирлын тушаалаар ажилтанд сахилгын шийтгэл оногдуулна.
- 19.4. Эрх бүхий албан тушаалтантай холбоотой дүгнэлтийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороогоор хэлэлцэн шийдвэрлэсэн дүгнэлтийг үндэслэн ТУЗ холбогдох шийтгэлийг оногдуулна.
- 19.5. Энэ Дүрмийг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хууль болон Компанийн хөдөлмөрийн дотоод журам, ажилтантай байгуулсан гэрээнд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 19.6. Энэ Дүрмийг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжтэй бол эрх бүхий байгууллагад мэдээлэн Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

20. Бусад зүйл

- 20.1. Ёс зүйн хороо нь энэхүү Дүрмийн хэрэгжилт, илэрсэн ёс зүйн зөрчил, тэдгээрийг шийдвэрлэсэн явцыг улирал тутам гаргаж, ТУЗ-ийн дэргэдэх Байгаль орчин, нийгэм, засаглалын хороогоор дамжуулан ТУЗ-д тайлагнана.